



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 71

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5.9, 5.11 дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 09 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч орон нутгийн өмчид бүртгэлгүй явж ирсэн 39-28 ДУА улсын дугаартай УАЗ-31519 маркын автомашиныг 900,000.00 /Есөн зуун мянган төгрөг/, Биеийн тамир, спортын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 89-62 ДУА улсын дугаартай 8,140,500.00 /найман сая нэг зуун дөчин мянга таван зуун/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн УАЗ-31512 маркын автомашиныг 750,000.00 /Долоон зуун тавин мянган/ төгрөгөөр худалдан авах хүсэлт гаргасан анхны хүнд худалдахыг тус тус зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг хууль журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогоос 39-28 ДУА улсын дугаартай УАЗ-31519 маркын автомашины татварын тооцоог барагдуулж үлдэгдлийг, бусад хөрөнгөөс орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Биеийн тамир, спортын газар /М.Наранбадрах/-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХТ-ийн 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 54 дүгээр тогтоолын 1 дэхь заалтыг хүчингүй болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцэцэг үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР